



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/103-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-15
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТАГ	Төрийн аудитын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН 4 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ГАНТӨМӨР ТАНАА

2025.02.25 № СНА-2025/105-НА-СНА-МЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн хавсран ажилласны нэмэгдлийг илүү тооцож олгосон, төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас ХХОАТ-ын авлага, НДШ-ийн өглөг үүсгэсэн зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон 4,613.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 5,694.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	65,589,462.21	81,542,634.12
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	46,927,932.21	51,821,879.12
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	46,927,932.21	51,821,879.12
31210	Төгрөг	46,927,932.21	51,821,879.12
31211	Төрийн сангийн харилцах	46,927,932.21	51,821,879.12
33	АВЛАГА	0.00	5,000,000.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	5,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,661,530.00	24,720,755.00
35400	Хангамжийн материал	18,661,530.00	24,720,755.00
35410	Бичиг хэргийн материал	112,900.00	112,900.00
35420	Аж ахуйн материал	3,251,100.00	6,351,600.00
35450	Барилгын засварын материал	1,134,800.00	3,954,800.00
35460	Хүнсний материал	524,275.00	463,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,638,455.00	13,838,455.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	867,970,201.53	853,878,865.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	867,970,201.53	853,878,865.00
39200	Биет хөрөнгө	835,195,201.39	821,353,864.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	930,000,000.00	930,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(134,333,333.66)	(149,833,333.70)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	55,642,400.00	59,192,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,031,477.06)	(32,181,197.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,066,208.62	25,866,207.62
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,954,514.32)	(19,913,735.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,164,712.90	21,164,712.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,358,795.09)	(12,941,189.49)
39300	Биет бус хөрөнгө	32,775,000.14	32,525,000.18
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.86)	(1,124,999.82)
39303	Бусад биет бус хөрөнгө	32,400,000.00	32,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	933,559,663.74	935,421,499.12
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,337,820.05
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,337,820.05
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	10,337,820.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,400,000.00	32,400,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	32,400,000.00	32,400,000.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	32,400,000.00	32,400,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	901,159,663.74	892,683,679.07
51210	Өмнөх үеийн үр дүн	901,159,663.74	901,159,663.74
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-8,475,984.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	933,559,663.74	935,421,499.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	468,499,878.41	632,887,191.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,105,000.00	14,498,249.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,105,000.00	14,498,249.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,905,000.00	9,498,249.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	200,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	452,394,878.41	618,388,942.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	405,989,900.00	573,052,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	405,989,900.00	573,052,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,404,978.41	45,336,642.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,404,978.41	45,336,642.33
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	461,323,785.43	640,982,780.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,323,785.43	640,982,780.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	461,323,785.43	635,287,961.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,269,606.39	458,997,401.96
210101	Үндсэн цалин	215,479,754.58	318,414,004.94
210102	Нэмэгдэл	83,186,361.91	126,919,147.02
210104	Урамшуулал	13,603,489.90	13,664,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,981,522.72	58,636,742.18
210201	Тэтгэврийн даатгал	25,425,339.50	42,120,426.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,699,761.74	4,151,066.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,362,577.00	2,166,946.05
210204	Ажилгүйдлийн даатгал	589,579.35	1,994,164.30
210205	Эрүүл мэндийн даатгал	5,904,265.13	8,204,138.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,206,578.41	25,337,442.33
210301	Гэрэл, цахилгаан	6,104,618.41	5,721,252.33
210302	Түлш, халаалт	15,280,000.00	14,580,055.86
210303	Цэвэр, бохир ус	1,821,960.00	5,036,134.14
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00
2105	Нормативт зардал	29,669,725.00	32,425,685.00
210502	Хоол, хүнс	29,669,725.00	32,425,685.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,198,400.00	16,979,200.00
210604	Урсгал засвар	23,198,400.00	16,979,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	736,400.00	2,413,100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,125,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	736,400.00	288,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,261,552.91	40,498,389.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,502,330.00	10,702,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,804,300.00	3,636,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,954,922.91	26,159,189.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	5,694,819.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5,694,819.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,694,819.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,176,092.98	-8,095,589.02
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	0.00	380,395.65
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	7,176,092.98	-8,475,984.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	452,394,878.41	623,388,942.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	452,394,878.41	618,388,942.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	405,989,900.00	573,052,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	405,989,900.00	573,052,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	46,404,978.41	45,336,642.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	46,404,978.41	45,336,642.33
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	435,523,187.52	618,494,995.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,523,187.52	618,494,995.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	435,523,187.52	609,850,176.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	312,269,606.39	459,049,920.47
210101	Үндсэн цалин	215,479,754.58	318,466,523.45
210102	Нэмэгдэл	83,186,361.91	126,919,147.02
210104	Урамшуулал	13,603,489.90	13,664,250.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,981,522.72	53,246,403.62
210201	Тэтгэврийн даатгал	25,151,194.53	36,730,088.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,973,906.71	4,151,066.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,362,577.00	2,166,946.05

210204	Ажилгүйдлийн даатгал	589,579.35	1,994,164.30
210205	Эрүүл мэндийн даатгал	5,904,265.13	8,204,138.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,206,578.41	25,337,442.33
210301	Гэрэл, цахилгаан	6,104,618.41	5,721,252.33
210302	Түлш, халаалт	15,280,000.00	14,580,055.86
210303	Цэвэр, бохир ус	1,821,960.00	5,036,134.14
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	38,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	38,000.00
2105	Нормативт зардал	28,919,850.00	32,364,410.00
210502	Хоол, хүнс	28,919,850.00	32,364,410.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,198,400.00	19,999,200.00
210604	Урсгал засвар	23,198,400.00	19,999,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	601,400.00	2,413,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	2,125,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	601,400.00	288,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,345,830.00	17,401,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,541,530.00	15,321,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,804,300.00	2,080,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,644,819.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5,694,819.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,694,819.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	2,950,000.00
213304	Хөрөнгийн	0.00	2,950,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	16,871,690.89	4,893,946.91
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	16,871,690.89	4,893,946.91
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		46,927,932.21
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		51,821,879.12

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00	0.00	901,159,663.74	933,559,663.74
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-8,475,984.670	-8,475,984.67
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,400,000.00	0.00	892,683,679.07	925,083,679.07

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	662,955,500.00	618,494,995.42	44,460,504.58	93.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	662,955,500.00	618,494,995.42	44,460,504.58	93.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	662,955,500.00	609,850,176.42	53,105,323.58	92.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	491,369,100.00	459,049,920.47	32,319,179.53	93.4
210101	Үндсэн цалин	320,514,600.00	318,466,523.45	2,048,076.55	99.4
210102	Нэмэгдэл	165,724,900.00	126,919,147.02	38,805,752.98	76.6
210104	Урамшуулал	5,129,600.00	13,664,250.00	(8,534,650.00)	266.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,293,100.00	53,246,403.62	6,046,696.38	89.8
210201	Тэтгэврийн даатгал	40,319,800.00	36,730,088.40	3,589,711.60	91.1
210202	Тэтгэмжийн даатгал	4,743,000.00	4,151,066.08	591,933.92	87.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,371,700.00	2,166,946.05	204,753.95	91.4
210204	Ажилгүйдлийн даатгал	2,371,700.00	1,994,164.30	377,535.70	84.1
210205	Эрүүл мэндийн даатгал	9,486,900.00	8,204,138.79	1,282,761.21	86.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,723,700.00	25,337,442.33	7,386,257.67	77.4
210301	Гэрэл, цахилгаан	10,779,200.00	5,721,252.33	5,057,947.67	53.1
210302	Түлш, халаалт	15,732,200.00	14,580,055.86	1,152,144.14	92.7
210303	Цэвэр, бохир ус	6,212,300.00	5,036,134.14	1,176,165.86	81.1
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	38,000.00	(38,000.00)	
210401	Бичиг хэрэг	0.00	38,000.00	(38,000.00)	
2105	Нормативт зардал	32,986,100.00	32,364,410.00	621,690.00	98.1
210502	Хоол, хүнс	32,986,100.00	32,364,410.00	621,690.00	98.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,999,200.00	800.00	100.0
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,999,200.00	800.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	6,332,900.00	2,413,100.00	3,919,800.00	38.1

	төлбөр, хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	2,125,100.00	2,874,900.00	42.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,332,900.00	288,000.00	1,044,900.00	21.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,250,600.00	17,401,700.00	2,848,900.00	85.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,826,900.00	15,321,300.00	505,600.00	96.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,423,700.00	2,080,400.00	2,343,300.00	47.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	8,644,819.00	(8,644,819.00)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	5,694,819.00	(5,694,819.00)	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	5,694,819.00	(5,694,819.00)	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	2,950,000.00	(2,950,000.00)	
213304	Хөрөнгийн	0.00	2,950,000.00	(2,950,000.00)	
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,950,000.00	(2,950,000.00)	
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	2,950,000.00	(2,950,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	623,388,942.33	(623,388,942.33)	
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	618,388,942.33	(618,388,942.33)	
131001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	573,052,300.00	(573,052,300.00)	
	Орон нутгийн төсөв	0.00	45,336,642.33	(45,336,642.33)	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	5,000,000.00	(5,000,000.00)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00	(5,000,000.00)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		46,927,932.21	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		51,821,879.12	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэг нь “Хамтын оролцоог дэмжин, ёс зүйг эрхэмлэж, багшлахуй ба суралцахуйн хөгжил, төлөвшил, үр дүн, чанарт ахиц гаргая” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг тодорхойлжээ. Үүнд:

- Сум, орон нутгийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлж, багш бүр ажлын байран дээрээ хөгжиж, мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллан, байгууллагын эерэг уур амьсгал, соёлыг төлөвшүүлэх
- Байгууллагын менежмент, үнэлгээнүүдийн үр дүнг сайжруулж, ТАТ/тогтмол ажлын төлөвлөгөө, САТ/сарын ажлын төлөвлөгөөг/-г хэрэгжүүлж цахим платформд суурилсан сургалтыг хөгжүүлэх,
- Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд бүрийн тэгш, хүртээмжтэй, эрүүл, аюулгүй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх.
- Санхүүжилтийг зориулалтын дагуу хамт олны оролцоотойгоор төлөвлөж, хэрэгжилтийг үр дүнтэй, ил тод, нээлттэй байлгах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,861.8 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	46,928.0	51,821.9	4,893.9
Авлага		5,000.0	5,000.0
Бараа материал	18,661.5	24,720.8	6,059.3
Үндсэн хөрөнгө	867,970.2	853,878.8	(14,091.4)
Нийт хөрөнгө	933,559.7	935,421.5	1,861.8
Өр төлбөр		10,337.8	10,337.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	933,559.7	925,083.7	(8,476.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	933,559.7	935,421.5	1,861.8

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 51,821.9 мянган төгрөг болж 4,893.9 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Авлага дансны үлдэгдэл 5,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ХХОАТ-ыг илүү шилжүүлснээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 24,720.8 мянган төгрөг болж 6,059.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 62,455.4 мянган төгрөгийн бараа материал бэлтгэж, үйл ажиллагаанд 56,396.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 1,069,873.3 мянган төгрөг болж 4,350.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,950.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, эцэг, эхчүүдээс 1,400.0 мянган төгрөгийн зурагт, принтерийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, сумын Орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 371 дүгээр албан бичгээр ашиглалтын хугацаа нь дууссан дахин ашиглах боломжтой 8,098.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгасан, 26,159.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 437,334.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 44,723.7 мянган төгрөг, нийт 482,057.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 107,633.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийг нийт 589,691.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 57,801.7 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 2,681.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 6,332.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,448.5 мянган төгрөгөөр нийт 73,264.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 563,303.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 52,723.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 46,928.0 мянган төгрөг зарцуулахаар **662,955.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 662,955.5 мянган төгрөгийн орлого

бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 618,495.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 618,495.0 мянган төгрөг буюу 93.3 хувьтай байгаа нь хоолны зардлыг 4,183.5 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 40,277.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		1	80233 Хүүхэд хамгаалал	563.9	37.6	526.3	6.7
1	71802- Сургуулийн өмнөх боловсрол	2	81605- Эрүүл мэндийг дэмжих	1,020.8	1,020.8	-	100.0
		3	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	36,547.9	32,364.4	4,183.5	88.6
		4	81816- Зөв монгол хүүхэд	2,286.5	2,286.5	-	100.0
		5	81823- Боловсролын багшийн сургалт	1,020.8	1,020.8	-	100.0
		6	81834- Боловсролын стандарт сургалт	537,465.9	520,323.6	17,142.3	96.8
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	26,326.0	11,104.7	15,221.3	42.2
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	52,723.7	45,336.6	7,387.1	86.0
		9	83603-Нэмэлт санхүүжилт	5,000.0	5,000.0	-	100.0
		Нийт				662,955.5	618,495.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан, хоол хүнсний 32,364.4 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч

ирээгүй учраас Иргэн Шинэбаатар, Бямбадорж, “Шанзан ташуур” ХХК, “Япсомо” ХХК-иудтай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/11 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 461,323.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,613.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 4 дүгээр цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илүү олгосон ур чадварын нэмэгдлийг төлүүлэх 931.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх, мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хоцроосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт тогтоох	1	931.6	1	931.6	100.0
Албан шаардлага	2	2,674.0	2	2,674.0	100.0
Нийт дүн	3	3,605.6	3	3,605.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 5,000.0 мянган төгрөгийг алдааг залруулсан. Үүнд:

- ХХОАТ-ыг илүү шилжүүлснээс үүссэн 5,000.0 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1: “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.2: “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитаар 16,674.6 мянган төгрөгийн зөрчил илэрч 1,336.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 15,337.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага, зэрэгцсэн хөдөлмөр эрхэлж буй ажиллаж буй нягтлан бодогчийн цалинтай холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогч Н.Тунгалагийн хавсран ажилласны нэмэгдлийг 100 хувиар тооцож 1,336.8 мянган төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” болон эрхлэгчийн 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дүгээр “нягтлан бодогч Н.Тунгалаг-60 хувь” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 5,000.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлага, 10,337.8 мянган төгрөгийн НДШ-ийн өр төлбөр тус тус үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр

үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.1. Илрүүлэлт: Мөнгөн хараа чуулгад үндсэн орон тоонд нягтлан бодогчоор ажиллаж буй Н.Тунгалагийг тус цэцэрлэгт зэрэгцсэн хөдөлмөрөөр нягтлан бодогчоор ажиллуулан, цалинжуулж /5-12 саруудад үндсэн цалинг 100.0 хувиар тооцож/ байгаа нь дараах хуулиудыг тус тус зөрчиж байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх " Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ" 37.1.17: "Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх",
- 38 дугаар зүйлийн 38.1 дэх "Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ", 38.1.6: "Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх", 38.1.7:"Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх....",
- Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь "Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой бөгөөд үүнд ажилтан, үндсэн болон зэрэгцсэн ажил олгогч тус тус хяналт тавина", 84 дүгээр зүйлийн 84.4 дэх " Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэх мэт.

1.2 Өгсөн зөвлөмж: 2 байгууллагад зэрэгцээ хөдөлмөрөөр нягтлан бодогчийн албан тушаал эрхлүүлж буй зөрчлийг таслан зогсоож, зайлшгүй тохиолдолд 1-ээс илүү зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэхгүй байж, цалинг өдрийн 4 цагаар бодож, 50.0 хувиас хэтрүүлэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5¹ дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 –ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс							
							Запруулсан				Запруулаагүй		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайланд авлага тайлагнаагүй	1	5,000.0	1	5,000.0			1	5,000.0						
Дүн	1	5,000.0	1	5,000.0			1	5,000.0						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү олгосон	1	1,336.8	1	1,336.8								
Авлага, өр төлбөр үүсгэсэн	1	15,337.8			1	15,337.8						
Зэрэгцээ хөдөлмөр эрхлэлт	1						1					
Дүн	3	16,674.6	1	1,336.8	1	15,337.8	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										